



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 408

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байрлалтай хуваарилах байгууламж №7-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөх” төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон 1,259,519,485.00 (нэг тэрбум хоёр зуун тавин есөн сая таван зуун арван есөн мянга дөрвөн зуун наян таван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН "УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ"
 ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хүчин чадал		Балансын үнэ (тегереер)
			Хэмжих нэгж	Биет хэмжээ	
1	Өмнөд дэд станцаас ШУТО РП-7 Энхтайваны гүүр хүртэл хос нэмэлт кабель шугам 6 кв	2013	м	6 кв-ын ЦДКШ 5225 м	286,816,535.25
2	Энхтайваны гүүрний доор Төмөр замаас ШУТО РП-7 А.Б кабель шугам 6 кв	2013	м	7 кв-ын ЦДКШ 5400 м	412,702,949.75
3	Хаалттай хуваарилах байгууламжийн тоноглол	2012	ком	РП-ны тоноглол 1	560,000,000.00
					1,259,519,485.00
Нийт дүн					(нэг тэрбум хоёр зуун тавин есөн сая таван зуун арван есөн мянга дөрвөн зуун наян таван)